

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
БАЙДАЛ

2019/02



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ,НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2015-2019 ОН	2
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	4
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	5
 НИЙГМИЙН ДААТГАЛ	7
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	8
 ЭРҮҮЛ МЭНД	9
 СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР	11
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	12
 ГЭМТ ХЭРЭГ	12
 ТӨСӨВ	14
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	14
 АЖ ҮЙЛДВЭР	15
 ХАРИЛЦАА ХОЛБОО	17
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	17



ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2019
Суурин хүн ам, жилийн эцэст	тоо	35 813	36 425	36 911	37608	-
Шинээр төрсөн хүүхэд	тоо	125	108	106	130	143
Ажилгүйчүүд, сарын эцэст	тоо	730	833	328	212	134
Үүнээс: эмэгтэй	тоо	371	517	169	94	70
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	193	87	83	33	80
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	70	72	55	96	75
Орон нутгийн төсвийн орлого	сая төгрөг	741.8	3 453.1	3 144.1	3 327.2	3 774.2
Орон нутгийн төсвийн зарлага	сая төгрөг	603.3	3 291.5	2 567.6	2 794.1	3 422.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгт 2. Дүүргүүдийн эдийн засаг, нийгмийн байдлын харьцуулсан үзүүлэлт

	Хэмжих Нэгж	2018 оны II сард					2019 оны II сард				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	302	Баянгол	7 530	Налайх	54	308	Баянгол	7 714	Налайх	55
			Чингэлтэй	1 786	Багануур	47		Чингэлтэй	1 766	Багануур	48
			Сүхбаатар	664	Багахангай	29		Сүхбаатар	699	Багахангай	31
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	85	Багахангай	504	Налайх	73	87	Багахангай	633	Баянгол	60
			Багануур	276	Хан-Уул	52		Багануур	137	Хан-Уул	55
			Чингэлтэй	115	Баянгол	42		Баянзүрх	159	Сонгинохайрхан	48
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	12	Чингэлтэй	18	Баянзүрх	8	16	Налайх	21	Баянгол	9
			Сонгинохайрхан	15	Налайх	7		Сонгинохайрхан	18	Хан-Уул	3
			Хан-Уул	14	Багахангай	-		Чингэлтэй	16	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	23	Баянзүрх	29	Баянгол	20	24	Баянзүрх	28	Сонгинохайрхан	16
			Багануур	26	Хан-Уул	20		Хан-Уул	26	Багануур	14
			Сүхбаатар	21	Багахангай	7		Чингэлтэй	25	Багахангай	2
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	118	Сүхбаатар	146	Налайх	9	95	Сүхбаатар	172	Багануур	14
			Чингэлтэй	116	Багануур	9		Чингэлтэй	67	Налайх	10
			Хан-Уул	50	Багахангай	6		Хан-Уул	55	Багахангай	5
18-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	57	Сүхбаатар	93	Хан-Уул	39	55	Сүхбаатар	82	Налайх	31
			Баянзүрх	66	Багануур	28		Чингэлтэй	61	Багануур	20
			Баянгол	65	Багахангай	15		Баянгол	61	Багахангай	18

Тайлбар: * - промилль

** - продицмилль

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2019 оны II сарын танилцуулга



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй, ажилгүй иргэдийн тоо 2019 оны эхний 2 сард 134 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 78 хүнээр (36.8%) буурсан ба 52.2 хувь нь эмэгтэйчүүд эзлэж байна.

Бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 12.7 хувь нь 15-24 насны залуучууд, 35.1 хувь нь 25-34 насныхан, 29.1 хувь нь 35-44 насныхан, 19.4 хувь нь 45-54 насны, 3.7 хувь нь 55-59 насны, 3.7 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй адил байна.

Хүснэгт 3. Дүүргийн ажилгүйчүүд, насны бүлэг, хүйсээр, жил бүрийн II сард

Үзүүлэлт	2016 II		2017 II		2018 II		2019 II	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажилгүйчүүд	833	517	374	198	212	94	134	70
Насны бүлгээр:								
15-24	123	72	85	39	32	14	17	6
25-34	292	197	122	64	88	40	47	27
35-44	203	119	92	60	50	23	39	21
45-54	139	81	65	31	30	14	26	12
55-59	36	22	8	2	7	3	5	4
60 +	40	26	2	2	5	-	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	19	8	8	2	2	2	5	3

Хүснэгт 4. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо				Дүнд эзлэх хувь			
	2016 II	2017 II	2018 II	2019 II	2016 II	2017 II	2018 II	2019 II
Ажилгүйчүүд, бүгд	833	374	212	134	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:								
Магистр, доктор	-	3	1	2	-	0.8	0.5	1.5
Дипломын болон бакалавр	166	65	36	27	20.0	17.4	17.0	20.1
Тусгай мэргэжлийн дунд	44	9	18	6	5.3	2.4	8.5	4.5
Техникийн болон мэргэжлийн	106	49	30	20	12.7	13.1	14.1	15.0
Бүрэн дунд	407	225	107	68	48.8	60.1	50.5	50.7
Суурь	72	19	12	8	8.6	5.1	5.6	6.0
Бага боловсрол	23	1	4	3	2.8	0.3	1.9	2.2
Боловсролгүй	15	3	4	-	1.8	0.8	1.9	-

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2019 оны эхний 2 сард шинээр төрсөн 143 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 41 хүнийг бүртгэлээс хасаж, 25 гэрлэлт, 12 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 хүүхдээр (10.0%), нас баралт өмнөх оны мөн үеэс 9 (28.1%) тус тус өссөн байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 52.4 хувь нь хүү, 47.6 хувь нь охин байна. Нийт нас баралтад 70.7 хувь нь эрэгтэй, 29.3 хувь нь эмэгтэй хүн эзлэж байна.

Хүснэгт 5. Төрөлт, нас баралтын бүртгэл, жил бүрийн II сард

Үзүүлэлт	2016	2017	2018	2019
Төрсөн хүүхэд, бүгд	108	106	130	143
Үүнээс: Эрэгтэй	52	55	69	75
Эмэгтэй	56	51	61	68
Нас баралт, бүгд	31	41	32	41
Үүнээс: Эрэгтэй	18	26	20	29
Эмэгтэй	13	15	12	12

Зураг 1. Хүн амын ердийн цэвэр өсөлт



Хүснэгт 6. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүн, насны бүлгээр, жил бүрийн II сард

Үзүүлэлт	2017			2018			2019		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Нийт	68	34	34	76	38	38	50	25	25
18-19	-	-	-	-	-	-	-	-	-
20-24	10	4	6	19	7	12	10	4	6
25-29	33	14	19	31	15	16	15	7	8
30-34	15	11	4	15	9	6	10	5	5
35-39	4	2	2	2	2	-	5	4	1
40-44	4	2	2	3	2	1	3	1	2
45-49	2	1	1	3	2	1	2	1	1
50 +	-	-	-	3	1	2	5	3	2

2019 оны эхний 2 сард гэрлэлтээ бүртгэлийн байгууллагаар баталгаажуулсан 25 хос байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 (34.2%) буурсан. Хосууд тайлант онд гэр бүл болон бүртгэлээ хийлгэсэн байна. Бүртгүүлсэн нийт гэр бүл бологч хүнийг насны бүлгээр нь ангилбал 20.0% нь 20-24 насны, 30.0% нь 25-29 насны, 20.0% нь 30-34 насны залуучууд, 10.0% нь 35-39 насны, 6.0% нь 40-44 насны, 4.0% нь 45-49 насны, 10.0% нь 50-аас дээш насныхан байна.

Хүснэгт 7. Гэр бүл цуцлалт, жил бүрийн II сард

Үзүүлэлт		2016	2017	2018	2019
Гэр бүл цуцлалт, бүгд		4	11	10	12
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)	1 хүртэл	-	1	-	1
	1-3	-	1	-	-
	4-6	-	2	1	2
	7-9	1	3	3	3
	10-14	1	3	4	4
	15-19	-	1	-	1
	20 ба түүнээс дээш	2	-	2	1

2019 оны эхний 2 сард нийт 12 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал, 8.3% нь 1 хүртэл жил, 16.7% нь 4-6 жил, 25.0% нь 7-9 жил, 33.4% нь 10-14 жил, 8.3% нь 15-19 жил, 8.3% нь 20 ба түүнээс дээш жил ханилсан хосууд байна.

Дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэр бүл цуцлалтын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 (20.0%) буурсан байна. Дүүрэгт 2019 оны эхний 2 дугаар сард үрчлэгдсэн 1 эрэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 8. Үрчлэлтийн үзүүлэлт, жил бүрийн II сард

Үзүүлэлт		2016	2017	2018	2019
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд		1	3	-	1
Үүнээс: насны бүлгээр					
3 хүртэл		1	3	-	1
3-6		-	-	-	-
7-9		-	-	-	-
10 ба түүнээс дээш		-	-	-	-

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэл, оюуны өмчийн хэлтэс



НИЙГМИЙН ДААТГАЛ

2019 оны эхний 2 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1891.2 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 741.3 сая төгрөг (39.2%) нь аж ахуйн нэгж, байгууллага, 950.9 сая төгрөг (50.3%) нь төсөвт байгууллага, 57.2 сая төгрөг (3.0%) нь эрүүл мэндийн даатгал, 10.1 сая төгрөг (0.5%) нь үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах, 131.7 сая төгрөг (7.0%) нь нөхөн шимтгэл, сайн дурын даатгуулагчдын шимтгэл байгаа юм.

Нийгмийн даатгалын сангаас 2019 оны эхний 2 сард 10655 даатгуулагч иргэнд 4061.8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.


Хүснэгт 9. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт, II сард

Үзүүлэлт	2018		2019		Даатгуулагчдын тоо	
	Даатгуу- лагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Даатгуу- лагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Тоо	Өсөлт, бууралт хувь
Нийт орлого	-	1 424.7	-	1 891.2	-	-
Нийт зардал	10 594	3 691.9	10 655	4 061.8	61 [↑]	0.6 [↑]
Тэтгэврийн даатгалын сан	9 346	3 073.4	9 535	3 444.6	189 [↑]	2.0 [↑]
Өндөр насны тэтгэвэр	6 427	2 121.1	6 621	2 380.8	194 [↑]	3.0 [↑]
Тахир дутуугийн тэтгэвэр	1 481	356.4	1 461	403.1	-20 [↓]	-1.4 [↓]
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	603	141.7	583	158.4	-20 [↓]	-3.3 [↓]
Цэргийн тэтгэвэр	835	454.2	870	502.3	35 [↑]	4.2 [↑]
ҮОМШӨ-ний даатгалын сан	965	446.4	888	438.7	-77 [↓]	-8.0 [↓]
Тахир дутуугийн тэтгэвэр	888	423.3	828	416.6	-60 [↓]	-6.8 [↓]
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	58	21.1	56	21.8	-2 [↓]	-3.4 [↓]
Сувиллын зардал	19	2.0	4	0.3	-15 [↓]	-78.9 [↓]
ҮОМШӨ ХЧТА ¹	-	-	-	-	-	-
Тэтгэмжийн даатгалын сан	254	120.4	206	133.5	-48 [↓]	-18.9 [↓]
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	130	10.3	103	12.6	-27 [↓]	-20.8 [↓]
Жирэмсний амралт	93	79.1	68	85.9	-25 [↓]	-26.9 [↓]
Оршуулга	31	31.0	35	35.0	4 [↑]	12.9 [↑]
Ажилгүйдлийн даатгалын сан	29	51.7	26	45.0	-3 [↓]	-10.3 [↓]
Ажилгүйдлийн тэтгэмж	29	51.7	26	45.0	-3 [↓]	-10.3 [↓]

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

¹ Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн чадвараа түр алдсан

Зураг 2. Даатгалын сангийн зарлага



Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 2019 оны эхний 2 дугаар сард 9535, олгосон тэтгэврийн хэмжээ 3444.6 сая төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 69.1 хувийг өндөр насны 11.7 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.6 хувийг тэжээгчээ алдсан, 14.6 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

2019 оны эхний 2 сард давхардсан тоогоор нийт 4843 хүнд халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ үзүүлж, халамжийн зардлын хэмжээ өссөн дүнгээр 1126.5 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 10. Нийгмийн халамжийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2018		2019		2019% 2018	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Мөнгөн дүн (сая төгрөг)	Өсөлт, бууралт хувь
	II	I-II	II	I-II	I-II	I-II
Халамжийн орлого, бүгд	-	1 354.1	-	1 205.4	-148.7↓	-11.0↓
Зарцуулалт, бүгд	3 887	1 178.0	4 843	1 126.5	-51.5↓	-4.4↓
Халамжийн тэтгэвэр	-	219.0	435	194.0	-25.0↓	-11.4↓
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	-	73.8	465	54.0	-19.8↓	-26.8↓
Ахмад настны хөнгөлөлт	51	11.4	30	32.5	21.1↑	2.8 дахин
Халамжийн үйлчилгээ	-	65.5	-	-	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд	103	12.2	48	8.7	-3.5↓	-28.7↓

Хүснэгт 10-ын үргэлжлэл

Үзүүлэлт	2016		2017		2019% 2018	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Мөнгөн дүн (сая төгрөг)	Өсөлт, бууралт хувь
	II	I-II	II	I-II	I-II	I-II
Эхчүүдийн мөнгөн тэтгэмж	413	20.5	587	23.3	2.8 [↑]	13.7 [↑]
Алдарт эхийн одонгийн тусламж	2 423	308.5	449	340.4	31.9 [↑]	10.3 [↑]
Алдар цолтой ахмад настнуудад олгосон	13	5.5	13	4.4	-1.1 [↓]	-20.0 [↓]
Хүнс тэжээл хөтөлбөрийн зардал	-	130.0	-	146.8	16.8 [↑]	12.9 [↑]
Амьжиргааг дэмжих зөвлөл	-	-	-	-	-	-
Насны хишгийн зардал	1 634	128.3	1 200	134.4	6.1 [↑]	4.8 [↑]
Цалинтай ээж хөтөлбөр	1 673	151.5	1 457	158.6	7.1 [↑]	4.7 [↑]
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	291	51.3	159	29.3	-22.0 [↓]	-42.9 [↓]
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	-	-	-	-	-	-
Өрх толгойлсон эцэг эхийн хөтөлбөр	-	-	-	-	-	-
Судалгааны зардал	-	-	-	-	-	-
Бусад зардал	-	0.5	-	0.1	-0.4 [↓]	-80.0 [↓]

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



ЭРҮҮЛ МЭНД

2019 оны эхний 2 сард төрсөн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 5 (7.1%), нас баралт 3 (13.0%) тус тус өссөн байна.

Хүснэгт 11.Төрөлт , жил бүрийн II сард

Үзүүлэлт	2016	2017	2018	2019
Амаржсан эхийн тоо, бүгд	121	108	138	142
Амьд төрсөн хүүхэд	119	112	141	142
Амьгүй төрсөн	3	-	-	-
Эхийн эндэгдэл	-	-	-	-
Нас баралт	29	46	38	49
Үүнээс: нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	4	3	1	3
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	7	1	5	4
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	14	36	30	38
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт ²	8	6	3	7

² Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт

2019 оны эхний 2 сард бүртгэгдсэн нийт нас баралтын 77.5 хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт эзэлж байгаа бол 14.3 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байгаад гарсан, 8.2 хувь хувийг дүүргийн эмнэлэгт гарсан нас баралт эзэлж байна.

Хүснэгт 12. Дүүргийн хэмжээнд гарсан халдварт өвчин, жил бүрийн II сард

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	10.0 мянган хүн тутам
Нийт халдварт өвчин	193	83	73	80	21.5
Хурц халдварт өвчин:	87	7	33	17	4.6
Хепатит В вирус	1	-	-	-	-
Хепатит С вирус	-	-	-	1	0.3
Менинжет	-	-	1	-	-
Салхин цэцэг	8	4	27	9	2.4
Гахайн хавдар	-	-	-	-	-
Паротит	-	-	-	1	0.3
Бруцеллез	-	-	-	1	0.3
Ёлом	-	-	-	-	-
Дизентери	-	-	3	2	0.5
Гар, хөл, амны өвчин	5	1	-	3	0.8
Хоолны хордлого	-	-	-	-	-
Сальмонеллэз	1	-	-	-	-
Улаан эсэргэнэ	-	2	1	-	-
Эритема	-	-	1	-	-
Улаан бүрхан	72	-	-	-	-
Сүрьеэ	12	10	11	14	3.8
Арьс өнгөний өвчин	94	66	29	49	13.3
Тэмбүү	30	11	12	10	2.7
Үүнээс: төрөлхийн	-	-	-	-	-
Заг хүйтэн	13	10	9	13	3.5
Хамуу	-	-	-	-	-
Бэлгийн замын мөөгөнцөр	22	29	2	12	3.2
Мөөгөнцөр	-	2	-	-	-
Трихомониаз	29	14	6	14	3.8

Эх үүсвэр: Эрүүл мэндийн төв

Эрүүл мэндийн үзүүлэлтээр дүүргийн хэмжээнд хурц халдварт өвчнөөр 17 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 (48.5%) хүнээр буурч, арьс өнгөний өвчлөл 49 гарсан нь 20 (68.9%) хүнээр, сүрьеэгээр 14 хүн өвчилсөн нь 3 (27.3%) тохиолдлоор тус тус өссөн байна. Нийт халдварт өвчний гаралт 80 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 (9.6%) өссөн байна.

Хүснэгт 13. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт, жил бүрийн II сард

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	Өсөлт, бууралт хувь
Урьдчилан сэргийлэх тарилга	1 052	1 043	961	953	-0.8↓
Амбулаторын үзлэг	29 533	28 928	34 848	28 634	-17.8↓
Ор хоног	8 103	8 428	9 340	9 572	2.5↑
Эмчийн тоо	69	68	75	78	4.0↑
Сувилагчийн тоо	104	95	98	105	7.1↑
Орны тоо	165	177	227	227	-

Зураг 3. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт



Амбулаторийн үзлэгийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 6214 (17.8%) ,урьдчилан сэргийлэх тарилга 8 (0.8%) буурсан байна. Ор хоног 232 (2.5%) өссөн байна.



СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2019 оны эхний 2 дугаар сард нийтдээ 5 төрлийн 35 ажил, үйлчилгээг явуулж, 500.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Хүснэгт 14. Соёл, урлагийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, жил бүрийн II сард

Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс:					Номын сан (уншигчид)	Музейн ³ үзэгчид
		Урлагийн тоглолт	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд	35	6	14	7	-	8	86	-

Эх үүсвэр : Соёл урлагийн ордон

³ Орон нутаг судлах танхим



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

2019 оны эхний 2 сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 38.1 сая төгрөг болж, орлогын 33.1 хувийг орон сууц, 27.0 хувийг гэр хороолол, 39.9 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 10.4 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

Хүснэгт 15. Хот тохижилтын үзүүлэлт, жил бүрийн II сард

Үзүүлэлт	2017	2018	2019	Үүнээс:		
				Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого, сая төгрөг	43.3	36.3	38.1	12.6	10.3	15.2
Хог тээвэрлэлт, мянган тонн	8.4	13.3	10.4	1.6	6.9	1.9

Эх үүсвэр: Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

Хүснэгт 16. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, жил бүрийн II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019
Шахсан ус	мянган м ³	234.5	215.2	127.7	182.4
Борлуулсан ус	мянган м ³	103.8	94.4	72.2	105.6
Үүнээс: Хүн амд	мянган м ³	51.1	56.0	49.6	57.1
Аж ахуйн нэгж байгууллагад	мянган м ³	52.7	38.4	22.6	48.5
Татан зайлуулсан бохир	мянган м ³	67.2	83.6	71.5	71.1
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	111.8	114.0	79.6	153.4
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	43.4	66.1	70.6	89.1
Халаалтын орлого	сая төгрөг	34.4	39.0	39.5	42.5

Эх үүсвэр: Чандмань Налайх ОНӨААТҮГазар

2019 оны эхний 2 сард дүүргийн хэмжээнд 105.6 мянган м³ ус борлуулснаас, 57.1 мянган м³ (54.0%) усыг хүн амд, 48.5 мян.м³ (46.0%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.



ГЭМТ ХЭРЭГ

Дүүрэгт 2019 оны эхний 2 сард 75 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21 гэмт хэргээр (21.8%) бүүрч, гэмт хэргийн илрүүлэлт 16.7 хувьтай байна.


Дээрх 75 гэмт хэрэгт 18 сэжигтэн яллагдагч холбогдсон бөгөөд насны ангиллаар авч үзвэл, 18-24 насны 2, 25-29 насны 1, 30-34 насны 4, 35-39 насны 4, 40-44 насны 2, 50-54 насны 3, 55-59 насны 2 хүн байна.

Хүснэгт 17. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн II сард

Үзүүлэлт		2016	2017	2018	2019
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд		72	55	96	75
Хүн амины	Санаатай	2	3	-	1
	Учрал	-	-	7	-
	Бусдыг болгоомжгүй алах	-	-	-	7
-Хүчин		-	1	1	1
Дээрэм				2	-
Танхай		2	2		-
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		-	-	5	1
Хулгай	Иргэдийн өмчийн	18	10	35	11
	Малын	-	-	4	4
	Халаасны хулгай				-
	Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн	-	-	-	
	Автомашины		2	1	-
Булаалт		-	-		
Залилан		1	4	7	5
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан		33	21	25	25
Авто тээвэр		3	2	2	2
Бусад		13	10	7	18
Хэрэгсэхгүй болгож мэдээнээс хасагдсан хэрэг		-	-	-	-
Илрүүлээгүй гэмт хэргийн тоо		6	5	80	55
Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь		70.0	72.2	8.0	16.7
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд		67	45	14	18
Үүнээс:	Ажилгүй	45	32	8	12
	Албан хаагч	3	1	1	-
	Сурагч	-	-	-	-
	Оюутан	2	3	1	-
	Малчин	1	-	-	-
	Тэнэмэл иргэд	-	-	-	-
	Төрийн бус байгууллагын ажилтан	-	-	-	1
	Хугацаат цэргийн алба хаагч	-	-	-	-
	ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч	16	9	4	5
Эрүүлжүүлэгдсэн хүн		-	-	-	555

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтэс

Зураг 4. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороодоор



Гэмт хэргийн улмаас 10 хүн нас барж, 29 хүн гэмтэж бэртсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 83.0 сая төгрөгийн хохирол учруулсны 7.4 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

2019 оны эхний 2 дугаар сард 4137 зөрчил илрүүлж, 3951 хүнийг 97.5 сая төгрөгөөр торгож, 555 (эмэгтэй 48) хүнийг эрүүлжүүлж, 55 хүний тээврийн хэрэгсэл

жолоодох эрхийг хасаж, 2 хүнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулжээ.


2019 оны эхний 2 сард сард гарсан гэмт хэргийн гаралт 1-р хороонд 20 гарч хамгийн өндөр байхад 6-р хорооны нутаг дэвсгэрт 2 гарч хамгийн байна.



ТӨСӨВ

2019 оны эхний 2 сард дүүргийн төсөвт 353.3 сая төгрөгийн татварын орлого төвлөрч, төлөвлөгөө 52.9 сая төгрөгөөр (17.6%) давж биелэв.

Татварын орлогын 55.8 хувийг хүн амын орлогын албан татвар, 10.2 хувийг хог хаягдлын үйлчилгээний хураамж, 2.9 хувийг түгээмэл тархацтай амнат, 0.3 хувийг бууны татвар, 4.6 хувийг улсын тэмдэгтийн хураамжийн орлого, 26.2 хувийг хүү торгуулийн орлого тус тус бүрдүүлсэн байна.



Эх үүсвэр: Татварын хэлтэс



ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс тэмээний шир 16000 төгрөгөөр (61.5%), адууны шир 3000 төгрөгөөр (20.0%), үхрийн шир 19500 төгрөгөөр (60.0%), хонины ноостой нэхий 2500 төгрөгөөр (62.5%) бүүрсан байна. Ямааны ноолууртай арьс 18000 төгрөгөөр (72.0%) өссөн.

байна.

Хүснэгт 18. Зарим түүхий эдийн үнэ, жил бүрийн II сард


Түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	Хувь
		төгрөг				
Тэмээний шир	ширхэг	20 000	25 000	26 000	10 000	-61.5↓
Адууны дэл	кг	4 000	-	-	10 000	-
Адууны сүүл	кг	8 000	-	-	12 000	-
Адууны шир	ширхэг	25 000	44 000	15 000	12 000	-20.0↓
Үхрийн шир (дундаж үнэ)	1.8-2.3 метр хэмжээтэй ширхэг	30 000	37 500	32 500	13 000	-60.0↓
Хонины ноостой нэхий	ширхэг	1 000	2 000	4 000	1 500	-62.5↓
Ямааны ноолууртай арьс	ширхэг	10 000	30 000	25 000	43 000	72.0↑

Хүснэгт 19. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2018.II.15					2019.II.13				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	1 480	1 665	2 010	-	-	1 780	1 735	2 280	-
Петровис	2 050	1 480	1 665	2 010	-	2 195	1 690	1 735	2 285	-
Магнай трейд	2 050	1 480	1 665	2 010	-	2 195	1 690	1 735	2 285	-
Сод монгол	-	-	1 660	2 010	-	2 190	-	1 735	2 280	-
Шунхлай	2 050	-	1 665	2 010	-	2 295	1 700	1 735	2 285	-
Юнигаз	-	-	-	-	1 200	-	-	-	-	1 300
Дундаж үнэ	2 050	1 480	1 665	2 010	1 200	2 219	1 715	1 735	2 283	1 300

Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн

Зураг 6. Нэг литр шатахууны дундаж үнэ жил бүрийн II сард



АЖ ҮЙЛДВЭР

2019 оны эхний 2 сард үйлдвэрлэгдсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 10.8 хувиар өсөж, усан хангамж 9.6 хувиар, дулаан хангамж 28.1 хувиар

буурсан байна.

Боловсруулах үйлдвэрийн хувьд оёдол 2.3 дахин, нарийн боов 3.6 дахин тус тус өссөн байна. Талх 6.1 хувиар, арьсан цүнх, түрийвч, эдлэл 20.3 хувиар тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 10.3 хувиар, дулаан хангамж 8.6 хувиар тус тус өсөж, усан хангамж 18.1 хувиар буурсан байна. Оёдол 4.3 дахин, нарийн боов 2.8 дахин тус тус өсөж, арьсан цүнх, түрийвч, эдлэл 20.3 хувиар 24.9 хувиар, талх 2.5 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 20. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, жил бүрийн II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт үйлдвэрлэлт					
		Биет хэмжээгээр			Үнийн дүнгээр, сая төгрөг		
		2017	2018	2019	2017	2018	2019
Эрчим хүчний үйлдвэр:							
Цахилгаан	сая.квт.цаг	17.1	20.4	22.6	2 410.9	2 988.3	3 296.4
Дулаан	мянган гкал	36.6	36.6	26.3	754.2	906.3	984.2
Усан хангамж	мянган м ³	215.2	352.7	318.7	73.2	103.4	84.7
Олборлох үйлдвэр:							
Шохой	тонн	-	-	-	-	-	-
Нүүрс	мянган тонн	0.8	0.25	-	49.0	14.6	-
Хайрга	мянган м ³	-	-	-	-	-	-
Элс	мянган м ³	-	-	-	-	-	-
Боловсруулах үйлдвэр:							
Тоосго	мянган ширхэг	-	-	-	-	-	-
Цемент	мянган тонн	-	-	-	-	-	-
Шохой	тонн	-	-	-	-	-	-
Оёдол	мянган ширхэг	0.4	4.5	13.5	20.6	42.5	226.9
Гэр ахуйн оёмол эдлэл	мянган ширхэг	-	1.4	0.3	-	10.9	5.1
Арьсан цүнх, түрийвч эдлэл	мянган ширхэг	-	12.3	9.8	-	53.7	40.3
Модон эдлэл	Мян.төг	-	-	0.9	-	-	0.9
Замаска	тонн	-	40.0	-	-	10.4	-
Барилгын шавардлагын хар замаска	тонн	-	46.0	-	-	11.9	-
Плитаны цавуу	тонн	-	29.5	-	-	9.7	-
Резинэн эдлэл	сая төгрөг	-	-	-	-	-	-
Хэвлэлийн будаг	мянган ширхэг	-	10.3	-	-	166.0	-
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл:							
Талх	тонн	-	7.8	7.32	-	15.6	15.2
Нарийн боов, жигнэмэг	тонн	-	3.0	10.8	-	7.4	21.0
Хэрчсэн гурил	тонн	-	0.3	-	-	0.2	-
Эмчилгээний цай	килограмм	-	-	905	-	-	29.6
Хүүхдийн тэжээл	тонн	-	-	-	-	-	-
Гүзээний чипс	тонн	-	-	0.02	-	-	0.7
Утсан чанасан болон хагас боловсруулсан мах	тонн	-	-	85.2	-	-	622.3
Өлөн гэдэс	мянган гогцоо	-	-	16.0	-	-	288.0
Цэвэр ус	мянган литр	-	-	901.3	-	-	128.7

Эх үүсвэр: Дүүргийн аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа тогтмол явуулсан ААН-ын дүнгээр



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа холбооны байгууллага 39.9 сая төгрөгийн орлоготой ажиллаж, үүнээс 19.5 сая төгрөг (48.8%) нь хүн амд үзүүлсэн үйлчилгээний орлого эзэлж байна.

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 46 (8.0%) өссөн байна. Нийт суурин телефон цэгийн 346 (56.1%) нь айл өрхийн эзэмшилд байгаа бол 201 (32.6%) нь төсвийн байгууллагад, 70 (11.3%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.

Хүснэгт 21. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019
Нийт орлого	сая төгрөг	35.0	33.2	35.7	39.9
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний	сая төгрөг	17.1	16.3	17.5	19.5
Телефон цэг	тоо	542	532	571	617
Үүнээс: айл өрх	тоо	313	399	317	346
Интернет үйлчилгээний цэг	тоо	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал	тоо	20	20	20	20
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид	тоо	3 840	3 440	979	588
Интернетийн байнгын хэрэглэгчид	тоо	198	179	195	147
Таксофон	тоо	1	1	1	1

Хүснэгт 23. Кабелийн телевизийн үзүүлэлт, жил бүрийн II сард

Үзүүлэлт/он	хэмжих нэгж	2016	2017	2018	2019
КТВ-ийн орлого	мян.төг	79 041.0	27 680.3	31 876.3	11 912.0
Хэрэглэгч	тоо	6 375	3 575	2 430	3 575



АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс 2019 оны эхний 2 сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж 74 аж ахуйн нэгж, байгууллагад 139 зөрчил илрүүлэн, 74 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 22, мэдэгдэл 21, ажиллагаа зогсоох тогтоол 2, зөрчлийн тэмдэглэл 6, дүгнэлт 3, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 20 хүргүүлсэн байна. Мөн объектын гал түймрийн 12 дуудлагаар ажиллаж, 74.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Хүснэгт 22. Гал түймрийн дуудлагын тоо, жил бүрийн II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019
Бүгд		18	16	18	12
Өмчийн хэлбэрээр:					
Төрийн өмч	тоо	-	-	4	2
Хувийн өмч	тоо	15	12	14	8
Аж ахуйн нэгж	тоо	3	4	-	2
Хамтын болон гадаад улсын өмч	тоо	-	-	-	-
Гал түймэрт өртөж шатсан:					
Нас барсан	хүүхэд	-	-	-	-
	том хүн	-	-	1	-
Түлэгдэж бэртсэн	хүүхэд	-	-	-	-
	том хүн	-	1	-	-
Өвөл зуны сууц	тоо	3	4	8	2
Гэр	тоо	3	1	2	1
Нийтийн орон сууц	тоо	-	-	-	-
Хог, хогийн суваг	тоо	4	4	4	2
Машин техник	тоо	2	3	2	1
Барилга байгууламж	тоо	1	2	-	2
Малын хашаа саравч	тоо	1	-	-	-
Шалтгаан:					
Цахилгааны	тоо	4	2	-	-
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	4	-	-	-
Лаа, тамхи, шүдэнз	тоо	-	-	4	3
Пийшин зуухны цонолт	тоо	5	1	-	-
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	1	2	1	-
Машин, техникийн яндангийн оч болон цахилгааны очноос	тоо	-	-	-	-
Архидан согтуурснаас	тоо	-	2	1	-
Газрын тосны бүтээгдэхүүний ашиглалтын буруугаас	тоо	-	-	-	-
Технологийн горим зөрчсөнөөс	Тоо	-	-	-	-
Бусад	Тоо	4	5	-	-
Шалтгаан тогтоогдоогүй	Тоо	-	4	12	9
Аварсан эд хөрөнгө:					
Хүн	тоо	-	-	-	-
Өвөл зуны сууц	тоо	2	3	4	2
Гэр	тоо	-	1	2	-
Барилга байгууламж	тоо	2	1	-	1
Машин техник	тоо	2	-	1	1
Нийтийн орон сууц	тоо	-	-	-	-
Улсын онц чухал болон галын онц аюултай объект	тоо	-	-	-	-
Малын хашаа саравч	тоо	-	-	-	-
Эд хөрөнгө	сая төгрөг	234.0	851.0	40.0	74.0

Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтэс

Хүснэгт 23. Газартай холбоотой асуудал шийдвэрлэлт, жил бүрийн II сард

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил өөрчлөх	Газар ашиглуулах эрх олгох
Иргэн, ААНБ-ын тоо	1	-	-	79	10	2	-	-

Эх үүсвэр: Өмч, газрын харилцааны алба

2019 оны эхний 2 сард дүүргийн Засаг даргын 3 захирамжаар нийт 80 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.



ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, www.ub1200.mn цахим хуудас, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2019 оны эхний 2 дугаар сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 224 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Эдгээрээс 192 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, шийдвэрлэх шатандаа явагдаж байгаа 19 санал хүсэлт байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 91.0 хувьтай. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 217 (96.9%) нь бичгээр, 7 (3.1%) нь утсаар ирсэн байна.

Эх үүсвэр: ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ

Танилцуулгыг татаж авах линк :

www.ubstat.mn
www.nad.ub.gov.mn
 Налайх дүүргийн Статистикийн хэлтэс facebook page

Утас: 7023-3672

УБ хот, Налайх дүүрэг ЗДТГ-ын байр 2 давхар 210 тоот